

4.Үнэлгээний асуулга “СЭНДЛИ ББСБ” ХХК /нэр/

Компанийн засаглалын үнэлгээний асуулга

Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхул авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ нь олон талт үр чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	<p>Төлөөлөн удирдах зөвлөл нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор шинэчлэн баталж, уг журмын Тав болон Зургаадугаар бүлэгт ТУЗ-ийн гишүүдийн эрх, үүрэг, Долоо дугаар бүлэгт ТУЗ-ийн даргын бүрэн эрх, Найм дугаарбүлэгт ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, түүний үүргийг тус тус нарийвчлан зохицуулсан.</p> <p>Мөн гишүүд ямар тохиолдолд хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвлөгөөг компанийн зардлаар авч болох талаарх зохицуулалтыг тус журмын 5 дугаар зүйлийн 5.12-т тусгасан.</p>		2	100
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамжхалааны бодлогын баримттай байна.	2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 22/09 тоот тогтоолын хавсралтаар баталсан.		2	100
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшилийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандaa байршуулна.	<p>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшилийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж www.sendly.mn вэб хуудсанд байршуулсан.</p> <p>ТУЗ болон түүний дэргэдэх хороод, ТУЗийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, үнэлгээг ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны 2025 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн 01 тоот тогтоолоор үнэлж, ТУЗ-д танилцуулсан.</p>		2	100
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба	ТУЗ-ийн бүрэлдэхүүний аль нэг хүйсийн эзлэх хувийг гuchaас доошгүй байх зорилтыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын шинэчилсэн журмын Нэр дэвшүүлэх хорооны чиг үүргийн хэсэгт буюу 10 дугаар зүйлийн 10.8 дахь заалтад тусгасан.		2	100

	<i>уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>			
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	ТУЗ-ийн 2024 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 08 тоот тогтоолын Хоёрдугаар хавсралтаар “ТУЗ-ийн гишүүдэд зориулсан сургалтын төлөвлөгөө”-г баталсан.	2	100
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗийн үйл ажиллагааг зохицстой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга боловсруулан ТУЗ-ийн даргаар хянуулан баталгаажуулсан. Цаашид ТУЗ-ийн нарийн бичгийн дарга жил бүр тайланг боловсруулан ТУЗийн даргаар хянуулан зохицуулах байгууллагад хүргүүлэх арга хэмжээг авч ажиллах болно.	2	100
ДҮН			12	100
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ				
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ				
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гиниүүн байхыг зорино.</i>	ТУЗ-ийн дарга болон гишүүдийн олонхыг хараат бус болгох зорилтыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын шинэчилсэн журмын Нэр дэвшүүлэх хорооны чиг үүргийн хэсэгт буюу 10 дугаар зүйлийн 10.8 дахь заалтад тусгасан.	1	50

	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь уйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцно.	ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтцэд 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тогтоолоор шинэчлэн Аудит, эрдэлийн удирдлагын хороо болгон гишүүдийг шинэчлэн томилсон.		2	100
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцно.	ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтцэд 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтцийг шинэчлэн Цалин урамшууллын хороог дангаар байгуулан, гишүүдийг томилсон. Тус хорооны чиг ҮҮргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны шинэчилсэн журамд тусгасан.		2	100
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтцэд 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтцийг шинэчлэн Нэр дэвшүүлэх хороог дангаар байгуулан, гишүүдийг томилсон. Тус хорооны чиг ҮҮргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны шинэчилсэн журамд тусгасан.		2	100

11	<p>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ Хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туришлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</p>	<p>ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтцэд 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтцийг шинэчлэн Аудит, эрсдэлийн удирдлагын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшиүүлэх хороо болгон шинэчилж, гишүүдийг томилсон.</p>		2	100
ДҮН			9	90	

ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 22/03 тоот тогтоолын хавсралтаар Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталсан байна. Хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.		2	100
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Сэндли ББСБ ХК-ийн албан ёсны вэб хуудас болох www.sendly.mn -д байршуулсан		2	100
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нолохж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээллийг тусгасан.	Компанийн санхүүгийн тайлан болон жилийн үйл ажиллагааны тайланг www.sendly.mn вэб хуудас болон Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээллэсэн бөгөөд үйл ажиллагааны тайланд эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээллийг тусгасан.		2	100

ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана

15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны эсурамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг Үргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжсоор хангах талаар тусгажс, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлийн 10.12.4 дэх заалтанд Хөндлөнгийн аудитын байгууллагатай харилцах харилцааг зохицуулсан байна. 2024 оны санхүүгийн тайланд аудит хийх компанийг тус заалтыг үйл ажиллагаанд мөрдөн ажилласан.	2	100
----	---	---	---	-----

16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурад 2025 оны 03 дугаар сарын 30-ны өдөр товлогдсон бөгөөд тус хуралд аудитын дүгнэлтийг ТУЗ-ийн дарга танилцуулсан.	1	50
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг Үргэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	2024 оны үйл ажиллагааны тайланд дотоод аудит, эрсдэлийн удирдлагын тогтолцооны талаар хийгдэж буй ажил, хийхээр төлөвлөж буй ажлыг тусгасан.	2	100

ДҮН

5 83.3

ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус Байдалд ТУЗ хяналт тавина.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлийн 10.19-10.21 дэх заалтуудад Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагаа, чиг үүрэг, бүтцийн талаар тусгасан байна.		2	100
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошигүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ири, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлagnана.	ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтцэд 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтцийг шинэчлэн Аудитын хороог Эрсдэлийн удирдлагын хороотой нэгтгэн Аудит, эрсдэлийн удирдлагын хороо болгон шинэчилж, гишүүдийг томилсон. Эрсдэлийн удирдлагын хорооны бодлогын баримт бичиг нь 2022 оны 12 дугаар сарын 27-ны Төлөөлөн Удирдах зөвлөлийн 22/09 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан байна.		2	100
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдааж буйгаа тайлбарлана.	“Эрсдэлийн удирдлагын бодлого”-ын хүрээнд мөн зах зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн ажиллаж байна. 2023 оны 6 дугаар сард “Эрсдэлийг үнэлэх хяналт тавих журам” -ыг баталж улирал бүр үнэлгээг хийн ажиллаж байна.		2	100

21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар 10-ны өдрийн 17 тоот тогтоолоор Комплаенсийн мэргэжилтэн Б.Хоролгаравыг томилсон. Комплаенсийн үйл ажиллагааны журмыг баталж үйл ажиллагаандaa дагаж мөрдөн ажиллаж байна.		2	100
----	---	--	--	---	-----

ДҮН

8 100

ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ

Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна

22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурал 2025 оны 03 дугаар сарын 30-ны өдөр товлогдсон бөгөөд тус хурлын хэлэлцэх асуудлаар ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг хэлэлцүүлэн батлуулсан.		2	100
----	---	--	--	---	-----

23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Цалин, урамшууллын бодлогын Хоёр, Гурав, Дөрөв, Тавдугаар бүлгүүдэд ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, компанийн нийт ажилчдын цалин урамшууллыг тогтоох, үнэлэх шалгуурын талаар тусгасан байна.		2	100
----	--	---	--	---	-----

24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.		Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын хэмжээ, түүнийг олгох шалгуурын талаар 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, Гүйцэтгэх удирдлагатай Онцгой нөхцөл бүхий гэрээг байгуулан ажиллаж байна.	1	50
----	--	--	---	---	----

ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ

25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 2.9.10 дугаар зүйлд “Компанийн хувьцаа эзэмшигчид болон удирдлагын хооронд, хувьцаа эзэмшигчдийн хооронд, компани болон бусад оролцогчдын хооронд сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд зуучлагчийн үүрэг гүйцэтгэн, компанийн эрх ашиг болон сайн засаглалын зарчимд нийцүүлэн оновчтой зохицуулалт хийх” талаар зохицуулсан заалт болон Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлыг зөрчлийг зохицуулах журмаар тус тус компани бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах харилцааг зохицуулан ажиллаж байна.	2	100	
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Компанийн жилийн үйл ажиллагаанд сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл болон бусад хамтрагч байгууллагуудтай хэрхэн ажилласан талаарх мэдээллийг тусган мэдээллэж байна.		2	100
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг ҮР дүнтэйгээр ажиллуулна.	Компанийн www.sendly.mn вэб хуудсанд компанийн мэдээлэл болон бусад оролцогч байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллаж буй талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээллэн ажиллаж байна.		2	100
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшилүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	“Хөдөлмөрийн дотоод журам”-д ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, нийгмийн асуудлыг шийдэх зохицуулалтыг тусган мөрдөн ажиллаж байна.		2	100

НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ

ТУЗ-ийн гишүүд компанийд бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно

	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ББСБ-ын “Ёс зүйн дүрэм” батлан, үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.		2	100
29	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	ББСБ-ын “Ёс зүйн дүрэм” батлан, үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.		2	100
30	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалтын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	ББСБ-ын “Ёс зүйн дүрэм”-д авлига, албан тушаалтын гэмт хэргээс ангид байх зохицуулалтыг тусгасан ба үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Улс төрд нөлөө бүхий этгээдтэй харилцах, эрсдэлийн хүчин зүйлтэй холбоотой “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-т тусган үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.		2	100
ДҮН				6	100
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	www.sendly.mn вэб хуудас болон www.mse.mn вэб хуудсанд үйл ажиллагааны тайланг нээлттэй байршуулсан. Мөн өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллийг www.facebook.com/Sendllymn хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.		2	100

33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солицох цахим сувгийг хөгжүүлнэ.	ТУЗ-ийн 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 09 тоот тогтоолоор “Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд цаашид тус хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах болно.		2	100	
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нохицлийг бүрдүүлнэ.	“Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ыг мөрдлөг болгон ажиллана. Мөн хувьцаа эзэмшигчидэд мэдээлэл хүргэхдээ олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглаж байна. Үүнд: Хурлын зартай холбоотой асуудлыг өдөр тутмын сонин, www.sendly.mn болон https://www.facebook.com/Sendlymn хуудас. Мөн орон нутаг дахь хувьцаа эзэмшигчидэд онлайнаар холбогдох програм ашиглаж хэлэлцэх асуудал, тайлангийн мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаж байна.		2	100	
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Сэндли ББСБ ХК нь “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг ТУЗ-ын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 22/03 тоот тогтоолоор батлан үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.		2	100	
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Сэндли ББСБ ХК нь “Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам” ТУЗ-ын 2022 оны 12 дүгээр сарын 27-ны өдрийн 22/09 тоот тогтоолоор батлан үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Цаашид сонирхлын зөрчилтэй хэлцлийн дүн, мэдээг зохицуулагч байгууллагад хүргүүлэн ажиллах болно.		2	100	
ДҮН					10	100
НЭГДСЭН ДҮН					69	95.83%